

Чуулганд тавтай морилно уу

Ерөнхийлөгч Томас С.Монсон

Есүс Христийн сайн мэдээнд итгэх итгэл, хичээл зүтгэлийн тань төлөө ах эгч та нартаа их баярлалаа.

Хайрт ах эгч нар минь, дахин хамтдаа чуулан уулзаж байгаа нь хэчнээн сайхан юм бэ. Сүм зохион байгуулагдсаны 180 жилийн ойг бид энэ чуулганаараа тэмдэглэж байна. Үнэнийг эрж, олоод, Их Эзэний удирдлагаар сайн мэдээг сэргээж, Сүмийг зохион байгуулсан Бошиглогч Иосеф Смитэд та бид их талархан баярлаж явдаг билээ.

1830 оны тэр өдрөөс хойш Сүм тогтвортой өсөн хөгжсөөр байна. Сүм жил бүр олон хүний амьдралыг өөрчилж, үнэнийг эрж байгаа улам олон хүмүүсийг манай номлогчид дэлхий даяар олсоор байна. Сүмд буцаж ирж байгаа хүмүүсийг болон шинээр хөрвөгчдийг хайраар хүрээлэн, гэртээ ирсэн мэт сэтгэгдэл төрөхөд нь туслахыг бид Сүмийн гишүүддээ дахин уриалж байна.

Ах эгч нар аа, Есүс Христийн сайн мэдээнд итгэх итгэл, хичээл зүтгэлийн тань төлөө их баярлалаа. Тойрог, салбар, гадас, дүүрэгтээ та бүхний хийдэг ажил үйлсийн төлөө бид талархал илэрхийлж байна. Та нар хүсэл эрмэлзэлтэйгээр, чин сэтгэлээсээ үйлчилж, сайн үйлсийг бүтээж байна. Их Эзэнийг дагаж, зарлигуудыг нь дуулгавартай сахихын төлөө хичээл зүтгэл гаргасны тань төлөө Тэрээр та бүхнийг адислах болтугай.

Бид сүүлчийн чуулганаас хойш, дэлхий даяар олон газарт амин чухал хүмүүнлэгийн тусламжаа үзүүлэхээ үргэлжлүүлсээр байна. Өнгөрсөн гурван сарын дотор л гэхэд, Францын Полинези, Монгол, Боливи, Перу, Аризона муж улс, Мексик, Португаль, Угандад хүмүүнлэгийн тусламж үзүүлээд байна. Саяхан газар хөдлөлтийн гамшигт нэрвэгдсэн Гайти, Чили улсууд болон цунамид нэрвэгдсэн бүс нутгуудад бид тусламж үзүүллээ. Эдгээр гамшгуудад нэрвэгдсэн Сүмийн гишүүддээ бид хайр энэрлээ илэрхийлж байна. Та нар бидний залбиралд байгаа шүү. Бүхий л нөөц боломжоо, олон тохиолдолд,

цаг зав, авьяас чадвар, мэдлэг туршлагаа хүмүүнлэгийн тусламжийн ажилд нэмэрлэн, бидэнд туслах хүсэлтэй байсан та бүхэнд чин сэтгэлийн талархлаа өргөн дэвшүүлж байна.

Хүмүүнлэгийн тусламжийн хөтөлбөр Халамжийн хөтөлбөрийн нэг хэсэг болсноос хойш эдүгээ 25 жил өнгөрчээ. Энэ хөтөлбөрөөс тусламж авсан хүмүүсийн тоог үнэн зөвөөр гаргах нь үнэхээр боломжгүй юм. Гамшиг хаана ч тохиолдлоо гэсэн тэнд очих хамгийн анхны тусламж үзүүлэгчдийн нэг байхыг бид үргэлж хичээх болно.

Сүм үргэлж өсч хөгжин, урагш ахисаар байна. Ийм өсөлт хөгжилтийн нэг үзүүлэлт бол ариун сүмүүдийг олноор барьж байгаа явдал мөн. Бид Юта муж улсын Пейсон хотод шинэ ариун сүм барихаар саяхан зарласан билээ. Ютагийн Огдены Ариун сүмийг эрс шинэчлэн засварлах гэж байгааг бас зарласан. Ирэх гурван сарын дотор бид Британий Колумб дахь Ванкувер хот; Аризона муж улсын Гил Валли; Филиппиний Кебу хотод шинэ ариун сүмийг онцгойлон адислах гэж байна. Энэ жилдээ багтан өөр ариун сүмүүдийг шинээр эсвэл дахин онцгойлон адислана. Сүмийн гишүүнчлэлийн тоо нэмэгдэхийн хэрээр бид дэлхий даяар ариун сүмүүдийг барьсаар байх болно. Хорвоог орхисон хайртай хүмүүсийнхээ төлөө ариун сүмд сая саяар тоологдох ёслолыг бид жилийн жилд гүйцэтгэсээр байна. Өөрсдийнхөө төлөө ариун сүмийн ёслолуудыг хийлгэж чадахгүй болсон хайртай хүмүүсийнхээ төлөө ёслолуудыг итгэлтэйгээр үргэлжлүүлэн гүйцэтгэцгээе.

Өнгөрсөн 10-р сарын Чуулганы дараахан, миний хайрт эхнэр Францес хальтирч унаснаас мөр, аарцагны ясаа хугалсныг та нараас олон нь мэдэж байгаа байх. Амжилттай болсон хоёр удаагийн мэс заслын дараа, хэдэн долоо хоног эмнэлэгт хэвтсэний үр дүнд эхнэр маань гэртээ гарч ирэх боломжтой болсон юм. Хайрт хань минь сайн байгаа, бие нь бүр сайжирч байгаа шүү. Эхнэр маань өнгөрсөн хагас сайн өдөр Залуу Эмэгтэйчүүдийн Ерөнхий цуглаанд оролцсон бөгөөд энэ долоо хоногийн эцсээр нэг хоёр хуралдаанд оролцохоор төлөвлөж байсан боловч намайг нааш гарахын өмнө гэргий минь, “Өнөөдөр би явна шүү!” гэлээ. Хар даа, тэр энд байж байгаа биз дээ! Та бүхний залбирлын төлөө, хайрт ханьд минь сайн сайхныг хүссэний төлөө бид хоёр та бүхэнд баярлаж явдаг шүү. Энэ ялдамд бид хоёр Тэнгэрлэг Эцэгтээ чин сэтгэлийн талархлаа илэрхийлж байна.

Ах эгч нар аа, бид энд заавар, сүнслэг удирдамж хүлээж авахаар хуран чуулаад байна. Сүмд шинээр орсон та нарыгаа мөн бэрхшээл, хүнд сорилт, цөхрөл гутрал тохиолдсон болон хайрт нэгнээ алдсан та бүхнийг бас тавтай морилно уу хэмээн урьж байна. Бид та нартаа хайртай, та нарын төлөө залбирч байдаг. Энэ хоёр өдрийн турш, сайн мэдээний янз бүрийн сэдвийг хөндсөн олон захиас өгөгдөх болно. Та нарт хандан үг хэлэх эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, захиасынхаа талаар тэнгэрийн тусламжийг эрэлхийлсэн билээ.

Бид сонсож, суралцан, Түүний Сүнсээр дүүргэгдэхийн төлөө би залбирч байна. Ийм байгаасай хэмээн би, бидний Аврагч, Их Эзэн, Есүс Христийн нэрээр залбирч байна, амен.